



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ ТӨРИЙН ӨМЧИТ
АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/39/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Энхтуяа
Утас: 261628 Цахим хаяг: enkhtuyaj@audit.gov.mn
Ашид баланс аудит ХХК-ийн захирал: Л.Майцэцэг
Утас: 99081568 Цахим хаяг: ashidbalance@gmail.com

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ШТШАБ	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ
БАЙГУУЛАМЖ ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Г. ГАНСҮХ ТАНАА

2024.03.15 № 07/422
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих төлөвлөгөө 398.6 сая төгрөг буюу 32.5 хувиар тасарсан нь тус орон нутагт Лекс ойл ХХК шинээр ашиглалтад орж, ижил төрлийн үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбоотой шилжүүлэн ачилтын тоо багассан нь нөлөөлжээ.

Газрын тосны бүтээгдэхүүний бөөний борлуулалт хийх төлөвлөгөө 100.0 хувь буюу 549.8 сая төгрөгөөр тасарсан нь газрын тосны бүтээгдэхүүн худалдан авах тендер 2 удаа зарласан боловч оролцогч байхгүйгээс борлуулалт хийгдээгүй байна.

Аудитын гол асуудал

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь шинээр батлагдсан холбогдох хууль тогтоомж болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай байгуулсан контрактын биелэлтийн шалгуур үзүүлэлтээр 1 зорилтын хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс биелэлтийг 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4,847,081,366.00	2,557,770,209.49
1.1.2	Дансны авлага	-	38,865,110.94
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	284,290,780.21	157,967,450.66
1.1.4	Бусад авлага	-	131,530,862.31
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	3,252,857,336.94	6,416,108,774.02
1.1.6	Бараа материал	250,925,839.72	271,266,746.21
1.1.7	Урьдчилж төлсөн зардал	24,552,800.00	18,000,000.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	8,659,708,122.87	9,591,509,153.63
1.2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
1.2.1	Үндсэн хөрөнгө	13,214,047,975.56	12,813,376,537.06
1.2.2	Биет бус хөрөнгө	1,386,878,576.94	1,368,360,392.31
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	95,475,488.61
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,600,926,552.50	14,277,212,417.98
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	23,260,634,675.37	23,868,721,571.61
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	33,784,545.12	3,842,899.12
2.1.1.7	Урьдчилж орсон орлого		131,530,862.31
2.1.1.9	Нөөц	12,577,184.05	-
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	46,361,729.17	135,373,761.43
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	107,532,962.97	124,669,700.20
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	107,532,962.97	124,669,700.20
2.2	Өр төлбөрийн нийт дүн	153,894,692.14	260,043,461.63
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: Төрийн	15,362,339,049.32	15,362,339,049.32
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	535,186,521.93	533,483,446.52
2.3.9	Хуримтлагдсан ашиг	7,209,214,411.98	7,712,855,614.14
	Эздийн өмчийн дүн	23,106,739,983.23	23,608,678,109.98
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	23,260,634,675.37	23,868,721,571.61

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

		/төгрөгөөр/	
Мөр	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого/цэвэр/	2,921,231,086.37	2,852,260,202.20
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг/алдагдал/	2,921,231,086.37	2,852,260,202.20
5	Хүүгийн орлого	657,895,892.18	863,614,638.96
8	Бусад орлого	805,000.00	773,737.22
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,103,047,511.09	2,351,341,734.24
11	Санхүүгийн зардал	-	180,200.00
12	Бусад зардал	5,582,410.00	-
13	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз(гарз)	(16,340,792.73)	(67,033,944.84)
14	Бусад ашиг/алдагдал	-	(7,110,000.00)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал/	1,454,961,264.73	1,290,982,699.30
19	Орлогын татварын зардал	147,669,576.75	133,695,657.14
20	Тайлант үеийн ашиг/алдагдал/	1,307,291,687.98	1,157,287,042.16

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

					/төгрөгөөр/	
Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг /алдагдал	Нийт дүн		
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,362,339,049.32	282,110,305.92	6,696,541,307.86	22,340,990,663.10		
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	249,579,500.00	249,579,500.00		
Залруулсан үлдэгдэл	15,362,339,049.32	282,110,305.92	6,946,120,807.86	22,590,570,163.10		
Тайлант үеийн ашиг, алдагдал	-	-	1,307,291,687.98	1,307,291,687.98		
Зарласан ногдол ашиг	-	-	(1,044,198,083.86)	(1,044,198,083.86)		
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	253,076,216.01	-	253,076,216.01		
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,362,339,049.32	535,186,521.93	7,209,214,411.98	23,106,739,983.23		
Залруулсан үлдэгдэл	15,362,339,049.32	535,186,521.93	7,209,214,411.98	23,106,739,983.23		
Тайлант үеийн үр дүн	-	-	1,157,287,042.16	1,157,287,042.16		
Зарласан ногдол ашиг	-	-	(653,645,840.00)	(653,645,840.00)		
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(1,703,075.41)	-	(1,703,075.41)		
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,362,339,049.32	533,483,446.52	7,712,855,614.14	23,608,678,109.98		

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

				/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31	
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,250,098,651.00	6,128,320,980.47	
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,213,354,195.00	3,100,021,712.47	
1.1.6	Бусад мөнгөн орлого	36,744,456.00	3,028,299,268.00	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,025,688,941.01	8,261,489,839.86	
1.2.1	Ажиллагчдад төлсөн	761,606,539.00	998,900,998.90	
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	226,603,562.62	279,256,598.60	
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	63,550,906.55	23,751,907.00	
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	54,810,338.08	74,520,405.69	
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	81,788,000.00	141,421,680.50	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	605,015,795.18	476,378,867.12	
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	199,050.00	342,225.00	
1.2.9	Бусад мөнгөн зардал	232,114,749.58	6,266,917,157.05	
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,224,409,709.99	(2,133,168,859.39)	
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	9,777,267,946.97	863,614,638.96	
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	9,119,372,054.79	-	
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	657,895,892.18	863,614,638.96	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,512,187,589.79	366,111,096.08	
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	978,093,155.37	312,076,368.81	
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	18,269,795.46	54,034,727.27	
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	5,515,824,638.96	-	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,265,080,357.18	497,503,542.88	
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,044,198,083.86	653,645,840.00	
3.2.1	Төлсөн ногдол ашиг	1,044,198,083.86	653,645,840.00	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,044,198,083.86)	(653,645,840.00)	
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,445,291,983.31	(2,289,311,156.51)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,401,789,382.69	4,847,081,366.00	
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,847,081,366.00	2,557,770,209.49	

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн
газрын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт, борлуулалт							
1	Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих	тонн	68,638.5	90,000.0	60,768.3	(29,231.7)	67.5
	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах	тонн	9,690.5	8,700.0	10,575.9	1,875.9	121.6
	Газрын тосны бүтээгдэхүүний бөөний борлуулалт хийх	тонн	-	6,000.0	-	(6,000.0)	-
2	Нийт орлого	мян/төг	3,579,932.0	3,727,100.7	3,716,648.6	(10,452.1)	99.7
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян/төг	2,921,231.0	3,427,100.7	2,852,260.2	(574,840.5)	83.2
	Дансны хүү, бусад орлого	мян/төг	658,701.0	300,000.0	864,388.4	564,388.4	288.1
3	Нийт зардал	мян/төг	2,124,970.7	2,878,229.9	2,425,665.9	(452,564.0)	84.3
	Үүнээс: Удирдлагын зардал	мян/төг	298,152.0	483,565.4	475,153.3	(8,412.1)	98.3
4	Татварын өмнөх ашиг	мян/төг	1,454,961.3	848,870.8	1,290,982.7	442,111.9	152.1
5	Цэвэр ашиг/алдагдал	мян/төг	1,307,291.7	763,983.7	1,157,287.0	393,303.3	151.5
6	Төсвийн төлбөрт	мян/төг	740,028.9	694,140.8	554,911.2	(139,229.6)	79.9
7	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян/төг	0.59	0.77	0.65	84.5	(0.1)
8	Нийт авлага	мян/төг	284,290.8	-	196,832.6	196,832.6	
9	Нийт өглөг	мян/төг	153,894.6	122,532.9	128,512.6	5,979.7	104.9
	Үүнээс: Богино хугацаат өр төлбөр	мян/төг	46,361.7	15,000.0	3,842.9	(11,157.1)	25.6
	Урт хугацаат өр төлбөр	мян/төг	107,532.9	107,532.9	124,669.7	17,136.8	115.9
10	Хөрөнгө оруулалт	мян/төг	996,363.0	670,874.0	366,111.1	306,644.7	-
11	Ногдол ашиг	мян/төг	1,044,198.1	316,222.1	653,645.8	337,423.7	206.7
12	Нийт ажиллагсдын тоо	хүн	37	38	34	4	89.5
13	Нийт цалингийн сан	мян/төг	973,081.2	1,246,449.4	1,164,750.9	(81,698.5)	93.4
14	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян/төг	3,287.4	2,733.4	2,854.8	121.3	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Төмөр замаар тээвэрлэн нийлүүлж байгаа газрын тосны бүтээгдэхүүнийг Монголын вагон цистерн болон автоцистеринд шилжүүлэн ачих, хадгалах, үйл ажиллагааг тасралтгүй явуулах, газрын тосны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, цаашид тус байгууламжийн ашиглалтыг мэргэжлийн удирдлагаар хангах” гэж тодорхойлсон байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Газрын тосны бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих, хадгалах, ажлыг гүйцэтгэх;
- Газрын тосны бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллээр холбогдох байгууллагыг хангах;
- Олон улсын чанарын стандартад нийцсэн газрын тосны бүтээгдэхүүнийг зохих журмын дагуу импортлох;
- Газрын тосны бүтээгдэхүүний чанарт шинжилгээ хийх
- Үйлдвэрийн газар нь хөрөнгө оруулалт хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, судалгаа хийх;
- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах; хяналт тавих;
- Хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх;

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨААТҮГ гэсэн статустай, өмчийн 100.0 хувийг төр эзэмшиж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ нь Засгийн газрын 2009 оны 347 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах ...” гэсэн заалттай нийцэж байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ нь төлөөлөн удирдах зөвлөлгүй байна.

Тайлант хугацаанд ТӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Засгийн газрын 2022 оны 448 дугаар тогтоол “Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай”.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын захирлын 2019 оны А/04 дугаар тушаалаар “ШТШАБ” ТӨААТҮГ-ын дотоод хяналт шалгалтын журмыг баталж, мөрдөн ажиллаж байна. Дотоод хяналтын ажилтан нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажилтны ажлыг хавсран гүйцэтгэж байна. Тайлант онд 4 чиглэлээр 18 төрлийн ажил гүйцэтгэхээр төлөвлөгөө гаргаж, ТӨААТҮГ-ын захирлаар батлуулан, биелэлтийг 98.3 хувьтай гэж тайлагнасан байна.

Дотоод аудитын ажилтны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь шинээр батлагдсан холбогдох хууль тогтоомж болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарттай нийцээгүй, үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 608.1 сая төгрөгөөр буюу 2.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өөрчлөлт
	1	2	3=2-1
Б			
Мөнгөн хөрөнгө	4,847.1	2,557.8	(2,289.3)
Авлага	284.3	196.9	(87.4)
Бусад авлага	-	131.5	131.5
Бусад санхүүгийн хөрөнгө	3,252.9	6,416.1	3,163.2
Бараа материал	250.9	271.3	20.4
Урьдчилж төлсөн зардал	24.6	18.0	(6.6)
Үндсэн хөрөнгө	14,600.9	14,277.2	(323.7)
Нийт хөрөнгө	23,260.6	23,868.7	608.1
Богино хугацаат өглөг	46.4	3.8	(42.6)
Урьдчилж орсон орлого		131.5	131.5
Урт хугацаат өр төлбөр /Хойшлогдсон татварын өр/	107.5	124.7	17.2
Эздийн өмч	23,106.7	23,608.7	502.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	23,260.6	23,868.7	608.1

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,289.3 сая төгрөгөөр буурсан нь Төрийн банканд 2,121.0 сая төгрөгийн хугацаатай хадгаламж шинээр нээсэнтэй холбоотой байна.

Авлагын үлдэгдэл 196.9 сая төгрөг болж 87.4 сая төгрөгөөр буурсан нь татварын авлага данснаас НӨАТ-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5.б заалтын дагуу хойшлогдсон татварын хөрөнгө дансанд урт хугацаагаар хувь тэнцүүлэн залруулах бичилт хийсэн нь нөлөөлжээ.

Бусад авлага дансны үлдэгдэл 131.5 сая төгрөг болсон нь арилжааны банкнуудад байршуулсан хадгаламжийн хүүгийн авлагыг бүртгэсэнтэй холбоотой байна.

Бусад санхүүгийн хөрөнгө дансны үлдэгдэл 6,416.1 сая төгрөг болж 3,163.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд Хаан банкны 1,000.0 сая төгрөг, Төрийн банкны 2,000.0 сая төгрөгийн хадгаламжийн дансыг тус тус хааж, Худалдаа хөгжлийн банканд 4,000.0 сая, Төрийн банканд 2,121.0 сая төгрөгийн хугацаатай хадгаламж шинээр нээсэнтэй холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл 271.3 сая төгрөг болж 20.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан бараа материалын үлдэгдэл нөлөөлжээ.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 18.0 сая төгрөг нь шилжүүлсэн аудитын төлбөрийг урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 14,277.2 сая төгрөг болж 323.7 сая төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Тайлант онд 366.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 733 дугаар тогтоолоор тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглалтын шаардлага хангаж байгаа 17 нэр төрлийн 60.8 сая төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж 18.3 сая төгрөгөөр шинэчлэн дахин үнэлсэн;
- Татварын авлага данснаас хойшлогдсон татварын хөрөнгө дансанд 95.5 сая төгрөгийг шилжүүлэн бүртгэсэн;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 746 дугаар тушаалаар элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй 41 нэр төрлийн 261.4 сая төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 604 дугаар тушаалаар 75.0 сая төгрөгийн балансын үнэтэй, 7.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Дэу Солар-55 голд маркийн экскаваторыг Өвөрхангай аймгийн "Хархорин Ус суваг" ОНӨААТҮГ-т балансаас балансад шилжүүлсэн;
- Акталж, данс бүртгэлээс хасагдсан хөрөнгийн хорогдол 261.4 сая, тайлант онд 736.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой тус тус холбоотой байна.

Богино хугацаат өглөг 3.8 сая төгрөг болж, 42.6 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны жилийн эцсээр үүссэн өр төлбөрийг төлж барагдуулсан байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 131.5 сая төгрөг болсон нь арилжааны банкуудад байршуулсан хадгаламжийн гэрээнд заасан хугацааны хүүгийн орлогыг урьдчилж орсон орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Хойшлогдсон татварын өр дансны үлдэгдэл 124.7 сая төгрөг болж 17.2 сая төгрөгөөр өссөн нь ААНОАТ-ын тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлд элэгдэл тооцоогүй зөрүү дүнгээр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 23,608.7 сая төгрөг болж 502.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 2023 онд шинээр дахин үнэлсэн хөрөнгийн нэмэгдлийн зөрүү 1.7 сая, тайлант хугацааны цэвэр ашиг 1,157.3 сая төгрөг болон төлсөн ногдол ашиг 653.6 сая төгрөгийн зөрүүгээр нэмэгдсэн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын захирал нь байгууллагын эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 558 дугаар тогтоолоор Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 3,727.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,878.2 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 764.0 сая төгрөг байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын 22 арга хэмжээнд 670.9 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 3,716.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,425.7 сая төгрөгийн зардал гарган, 1,157.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 он	2023 он		Зөрүү	Хувь
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт борлуулалт						
1	Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих	тонн	68,638.5	90,000.0	60,768.3	(29,231.7)	67.5
	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах	тонн	9,690.5	8,700.0	10,575.9	1,875.9	121.6
	Газрын тосны бүтээгдэхүүний бөөний борлуулалт хийх	тонн	0.0	6,000.0		(6,000.0)	
2	Нийт орлого	мян.төг	3,579,932.0	3,727,100.7	3,716,648.6	(10,452.1)	99.7
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	2,921,231.0	3,427,100.7	2,852,260.2	(574,840.5)	83.2
	Дансны хүү, бусад орлого	мян.төг	658,701.0	300,000.0	864,388.4	564,388.4	288.1
3	Нийт зардал	мян.төг	2,124,970.7	2,878,229.9	2,425,665.9	(452,564.0)	84.3
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	298,152.0	483,565.4	475,153.3	(8,412.1)	98.3
4	Татварын өмнө ашиг	мян.төг	1,454,961.3	848,870.8	1,290,982.7	442,111.9	152.1
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	1,307,291.7	763,983.7	1,157,287.0	393,303.3	151.5
6	төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	740,028.9	694,140.8	554,911.2	(139,229.6)	79.9
10	Хөрөнгө оруулалт	мян.төг	996,363.0	670,874.0	366,111.1	(304,762.9)	54.6

Нийт орлогын гүйцэтгэл 3,716.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 10.5 сая төгрөг буюу 0.3 хувиар тасарсан нь газрын тосны бүтээгдэхүүний бөөний борлуулалт хийгээгүйтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,425.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 452.6 сая төгрөг буюу 15.7 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь цалин хөлс, нийгмийн даатгал, засвар үйлчилгээ, шатахуун, үндсэн хөрөнгийн элэгдэл, нийгмийн хариуцлагын хүрээнд хийх ажил, магадлашгүй ажлын зардал зэргийг батлагдсан төлөвлөгөөнөөс дутуу зарцуулсан нь нөлөөлжээ.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 22 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 366.1 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлжээ.

Тайлант онд цэвэр ашиг 1,157.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 393.3 сая төгрөгөөр илүү байгаа нь зардлын хэмнэлттэй холбоотой байна.

ТӨБЗГ-ын 2023 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 341 дүгээр тогтоолоор Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийг 653.6 сая төгрөгөөр тогтоосныг улсын төсөвт төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д *"Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана."* гэж заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр батлагдсан холбогдох хууль тогтоомж болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ашид баланс аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Алтанцэцэг, туслах аудитор Д.Сэрчинмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Л.Оюунчимэг, компанийн захирал Л.Майцэцэг нар анхан шатны чанарын хяналтыг, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Ж.Энхтуяа, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангаа Ашид баланс аудит ХХК-д 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 38 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 2,272.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 34.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэх зорилгоор тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 75.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий Дэү Солар-55 голд маркийн экскаваторыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 604 дүгээр тушаалаар Өвөрхангай аймгийн "Хархорин Ус суваг" ОНӨААТҮГ-т балансаас баланст шилжүүлсэн байна.

Энэ хуулийн хүрээнд ажлын ачааллыг нягтруулж, дутуу орон тоотой ажилласнаар цалин хөлс, нийгмийн даатгал зэрэг ажиллагсадтай холбоотой зардлыг 93.5 сая төгрөг буюу 6.6 хувиар хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 9 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ нь Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг цаг тухай бүрд нь бүрэн гүйцэт байршуулж ирсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нягтлан бүртгэл тайлагналтай холбоотой 7,131.6 сая төгрөгийн 4 алдаа илэрснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтыг үндэслэн аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн. Үүнд:

1. ХААН банк, Төрийн банкны "Хадгаламжийн гэрээ"-ний хугацаа дуусаж тус байгууллагын харилцах дансанд буцаан шилжүүлсэн 3,000.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний хэсэгт хөрөнгө оруулалт борлуулсны орлого гэсэн үзүүлэлтээр тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.
2. Худалдаа хөгжлийн банкттай шинээр хугацаатай хадгаламжийн гэрээ байгуулж, гэрээний дагуу 4,000.0 сая төгрөг хадгаламжийн дансандаа байршуулсныг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний хэсэгт хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн үзүүлэлтээр тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.
3. Хадгаламжийн хүүгийн орлогод төлсөн 18.2 сая төгрөгийн татварыг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зарлагад хадгаламж нээсэн мөнгөн дүнтэй хамт тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.
4. Санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэл цахим татварын тайлангийн эхний үлдэгдэл зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгснөөс бүрэн хэрэгжсэн байна.

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	2	-	100.0
Нийт дүн	2	-	2	-	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон нэмүү өртгийн албан татварын тооцооллыг цаг хугацааны хязгаарлагдмал байдлын улмаас нарийвчлан шалгаагүй тул дараагийн аудитаар энэ асуудлыг анхаарч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 131.5 сая төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Арилжааны банкнуудад байршуулсан хадгаламжийн гэрээнд заасан хугацааны хүүгийн /ХХБ 19.5 сая, Төрийн банк 104.2 сая, Хас банк 7.8 сая/ нийт 131.5 сая төгрөгийн авлагыг нягтлан бодох бүртгэлд авлага болон урьдчилж орсон орлогоор бүртгэж тайлагнаагүйг залруулсан.

Аудитаар НБББББ-тэй холбоотой 1 зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 34.1 сая төгрөгөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. НБББББ-тэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь шинээр батлагдсан холбогдох хууль тогтоомж болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарттай нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: НБББББ-ийг шинээр батлагдсан холбогдох хууль тогтоомж болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан зардал гаргахгүйгээр шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Арилжааны банкнуудад байршуулсан хадгаламжийн гэрээнд заасан хугацааны хүүгийн /ХХБ 19,528.7 мянга, Төрийн банк 104,223.4 мянга, Хас банк 7,778.7 мянга/ нийт 131,530.8 сая төгрөгийн авлагыг нягтлан бодох бүртгэлд авлага болон урьдчилж орсон орлогоор бүртгэж тайлагнаагүй.	1	131.5	-	-	-	-	1	131.5	-	-	-	-
Дүн	1	131.5	-	-	-	-	1	131.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Үүнээс												/сая төгрөгөөр/
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
									Тоо	Дүн			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн					
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь шинээр батлагдсан холбогдох хууль тогтоомж болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарттай нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-

[illegible]

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn
Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс